



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/017/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Энхжаргал

Утас: 99434344

Цахим хаяг: Enkhjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ5

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....5

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....

4. АУДИТЫН ТАЙЛАН.....

4.1 Ерөнхий зүйл

4.2 Материаллаг байдал

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ8

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....8

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ц.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

2025.09.21 № 2/НС
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Хязгаарлалттай” санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, эцсийн санхүүжилтийг хүлээн авсан акт, анхан шатны баримт дутуу байхад олгосон, багийн иргэдийн саналаар дэмжигдээгүй баяр ёслолын арга хэмжээ санхүүжүүлсэн 144.0 сая төгрөг
- Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эвлэрлийн гэрээ байгуулсан зээлдэгч нарын зээлийг хугацаанд нь төлүүлээгүй, зарим иргэдийн зээлийн үлдэгдлийг төлснөөр бүртгэж зээлийн мэдээллийн сангаас хассан, зээлийн хүүг дутуу тооцсон 60.9 сая төгрөг
- Соёлын төвийн цалингийн зардлаас 12 сард ажил эрхлээгүй 5 иргэнд гэрээт ажилтан нэрээр цалин олгосон асуудалд төрийн сангийн төлөөлөгч хяналт хийгээгүй 9.0 сая төгрөг

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүргийг хүлээнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан

"Зардлын эдийн засгийн ангилал"-тай, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.10-т "төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэсэн заалтуудыг мөрдөөгүй иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэбүрэн сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 593,542.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 171,250.6 мянган төгрөгөөр букуу 140.6 хувиар давуулан биелүүлсний дотор малын тоо толгойн албан татварыг төлөвлөөгүй, гүйцэтгэлээр 51,606.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд ~~үндэслэн гарах хэрэглэгчдийн~~ эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН, ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мян.төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	432,792.2	524,141.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	128,148.7	263,449.1
33	АВЛАГА	197,805.6	198,923.7
34	УРЬДЧИЛГАА	49,000.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	57,838.0	61,768.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,487,911.4	2,426,923.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,487,911.4	2,426,923.2
39200	Биет хөрөнгө	2,463,405.2	2,402,417.0
39300	Биет бус хөрөнгө	24,506.2	24,506.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,920,703.7	2,951,064.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	219.6	5,172.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	219.6	5,172.2
41300	Өглөг	219.6	5,172.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,920,484.1	2,945,892.7
51	Засгийн газрын хувь оролцоо	2,920,484.1	2,945,892.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	609,081.2	609,081.2
51200	Хуримтлагдсан үр дүн	2,082,321.5	2,107,730.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	229,081.4	229,081.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,920,703.7	2,951,064.9

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,245,357.0	2,553,812.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	427,000.1	518,416.5
110	Орлогын албан татвар	175,055.4	368,482.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	194,754.2	391,399.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-19,698.8	-22,917.4
113	Хөрөнгийн албан татвар	58,606.0	56,859.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	193,338.7	93,075.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	386,380.9	161,382.0
120	Нийтлэг татварын бус орлого	386,380.9	161,382.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,431,976.0	1,874,014.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,887,829.0	2,476,087.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,887,829.0	2,476,087.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,696,984.6	2,179,567.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477,371.6	763,672.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,040.2	94,346.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,583.1	507,689.5
2104	Хангамж, бараа материалын зардал	325,491.1	364,029.7
2105	Нормативд зардал	182.7	496.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,844.3	10,478.8
2107	Томилолт, зочны зардал	6,107.2	8,239.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	409,642.0	147,630.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	268,722.4	282,984.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,190,844.40	296,519.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	357,528.0	77,725.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	3,316.7

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	357,528.0	74,408.6
----	-------------------------------------------------	-----------	----------

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,890,809.6	2,467,556.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	427,000.1	518,416.5
110	Орлогын албан татвар	175,055.4	368,482.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	194,754.2	391,399.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-19,698.8	-22,917.4
113	Хөрөнгийн албан татвар	58,606.0	56,859.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	193,338.7	93,075.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	40,341.6	24,052.5
1181	Газрын төлбөр	1,282.9	1,879.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	151,714.2	67,143.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,833.5	75,126.2
120	Нийтлэг татварын бус орлого	31,833.5	75,126.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,431,976.0	1,874,014.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,307,808.5	1,860,140.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,307,808.5	1,860,140.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,116,964.1	1,565,124.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,949.1	761,610.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,261.1	95,198.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,583.1	507,689.5
2104	Хангамж, бараа материалын зардал	26,276.8	26,607.0
2105	Нормативт зардал	502.6	553.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,954.3	7,678.8
2107	Томилолт, зочны зардал	6,107.2	8,239.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	336,572.6	60,908.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,757.3	96,637.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,190,844.4	295,016.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	583,001.1	607,416.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	493,310.3	437,115.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	493,310.3	437,115.7
2200	Дотоод эх үүсвэрээр	493,310.3	437,115.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-493,310.3	-437,115.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-35,000.0	-35,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35,000.0	35,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	54,690.8	135,300.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	73,457.9	128,148.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	128,148.7	263,449.1

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,562,240.0	2,562,240.0

2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	716.2	716.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,562,956.1	2,562,956.1
9	Тайлант үеийн үр дүн	357,528.0	357,528.0
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,920,484.1	2,920,484.1
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,920,484.1	2,920,484.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-49,000.0	-49,000.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,871,484.1	2,871,484.1
19	Тайлант үеийн үр дүн	74,408.6	74,408.6
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,945,892.7	2,945,892.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,057,229.50	1,993,108.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,632,866.10	1,622,992.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,564,649.30	1,554,776.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	761,610.00	761,610.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,198.60	95,198.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	517,162.70	507,689.50
2104	Хангамж, бараа материалын зардал	24,932.10	24,932.10
2105	Нормативд зардал	553.7	553.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,078.80	7,678.80
2107	Томилолт, зочны зардал	8,239.80	8,239.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,158.40	58,158.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,715.20	90,715.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,216.80	68,216.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,216.80	68,216.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	384,363.40	335,115.70
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,000.00	35,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,057,229.50	2,081,489.60
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,935,314.50	2,006,751.40
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	121,915.00	74,738.20
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	34,356.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	122,737.60
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	62	62
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30	30
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12
620003	Үйлчлэх ажилтан	5	5

620004	Гэрээт ажилтан	4	4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30	30
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8
650010	Гэрээт ажилтан	4	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	2023 оны дүн	2024 оны дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	236,479.9	340,386.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,737.7	238,386.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,080.7	10,347.9
2104	Хангамж, бараа материалын зардал	6,075.9	1,674.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,307.7	2,750.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,697.1	5,922.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,657.0	228,038.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,657.0	226,800.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	149,742.2	102,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	149,742.2	102,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	236,479.9	340,386.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	236,479.9	340,386.7

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар ИТХ, ОНХС, ХХС, ТТЗ-ийн нийт 207,697.0 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс аудитын явцад 1,763.0 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг дутуу, хувь хүний орлогын албан татварын өглөгийг илүү бүртгэж, зарим нийгмийн даатгалын шийтгэлийн авлага өглөгийг тооцохгүйгээр шууд зардлаар бүртгэсэн 1,763.0 мянган төгрөгийг залруулсан.

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчилд² 1,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 204,934.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын дэд хөтөлбөрөөс зарцуулсан зардлын анхан шатны баримтгүй, юу хийсэн нь тодорхойгүй 1,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

¹ Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гэрсэн алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

5.2 Зөвлөмж

5.2.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэр бүхий 1 иргэний 6,907.5 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг программаас хасаж авлага бууруулсан, 1 иргэний зээлийн үлдэгдлийн 511.4 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн, Цамбагарав цаст уул ХХК-ний зээлийн хүү 1,602.0 мянган төгрөгийг нэмж бүртгээгүй, эдгээр нь Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэлгүй 9,021.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.3."төслийг хэрэгжүүлэх этгээдтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих"; 3.4.12 "Сумын хоршоо жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Монгол банкны зээлийн мэдээллийн санд илгээх мэдээллийг аймгийн хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнд илгээж хянуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зээлийн үлдэгдлийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд үнэн зөв мэдээлж бүртгүүлэх.

5.2.2. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Эвлэрлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг албадан гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулан ШШГА-тай гэрээ байгуулаагүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", "Хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" шүүгчийн захирамжуудын заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эвлэрлийн гэрээний хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийг ШШГГ-т хандаж албадан гүйцэтгүүлэх арга хэмжээ авах

5.2.3. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг Шүүхэд хандаж шийдвэр гаргуулаагүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний 3.3-д "Авсан зээл, түүний хүүгийн төлбөрийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй, зориулалтын дагуу зарцуулаагүй тохиолдолд зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар төлүүлэх, зохих журмын дагуу зээлийг төлүүлэх шаардлагатай бусад арга хэмжээ авна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийг Шүүхэд хандан шийдвэр гаргуулан барагдуулах арга хэмжээ авах

5.2.4. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлэх, төлөвлөх ажлын хэсэг томилж ажиллуулаагүй зөрчил нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 6.1 "Сум, дүүргийн засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан сум, дүүргийн засаг даргын захирамжаар байгуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-ын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ эрэмбэлж төлөвлөх ажлын хэсэг байгуулах

5.2.5. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд багийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй "Мөнгөлөг шагшуурга", "Галдан хааны 380 жил" зэрэг баяр ёслолын арга хэмжээний урсгал зардал санхүүжүүлсэн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.3 "үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал", 60.3.6 "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.3.2 "ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Багийн иргэдийн саналаар дэмжигдээгүй болон баяр наадам, ойн арга хэмжээ санхүүжүүлэхгүй байх.

5.2.6 Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цагдаагийн кобаны засвар 15.0 сая, Намаржин багийн 2 төвийн тохижилт хийх 20.0 сая, Шураг багийн зуслангийн тохижилт 20.0 сая, Хонгио багийн төвийн тохижилт 5.0 сая, Намаржин багийн Улаан дав чиглэлийн зам засвар 6.0 сая, Нэгдсэн хогийн цэг отболдох, нөхөн сэргээх, нэгдсэн цэвэрлэгээ 6.8 сая, Хар ус багийн гэрэлтүүлэг 20.0 сая, 49-н талбайн боолт хийх 10.0 сая, Баян зуслангийн зам засвар 7.0 сая, Малчдын сургалт 5.0 сая, Нохой устгал 5.6 сая зэрэг ажлуудыг ажлын даалгавар төсөвгүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, ажлын хэсэг томилон хүлээн авч акт үйлдээгүй, гэрээ дүгнээгүй, зургаар баримтжуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчил нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.2.2-т "Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих", 4.3.2 "ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" -г тус тус зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Захиалагчийн хяналт хэрэгжүүлэн, ажлын хэсэг томилон ажлыг актаар хүлээн авч акт үйлдэн гэрээг дүгнэж, анхан шатны баримтууд бүрдэл хангасны дараа үлдэгдэл санхүүжилтийг олгох

5.2.7 Орон нутгийн татварын орлоготой холбоотой асуудлаар

Илрүүлэлт: Малд ногдуулах албан татварын орлогыг төлөвлөөгүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д "төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах", 23 дугаар зүйлийн 23.8-д "Сум, дүүрэг,

орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.8.15-д "малын тоо толгойн албан татвар" заалтуудтай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Малын тоо толгойн албан татварыг төлөвлөх

5.2.8 Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар

Илрүүлэлт: Сумын Соёлын төвийн цалингийн зардлаас 12 сард ажил эрхлээгүй 5 иргэнд гэрээт ажилтан нэрээр цалин олгосон, ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний зардлыг анхан шатны баримтгүй олгосон зэргээр төрийн сангийн төлөөлөгч хариуцсан ажилдаа хяналт тавиагүй зөрчил нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал"-тай, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.10-т "төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг баримталж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 07 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын албааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
									Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2		3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Эрдэнэбүрэн сумын ИТХ	Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг дууруу, хувь хүний орлогын албан татварын өглөгийг илүү бүртгэж, зарим нийгмийн даатгалын шийтгэлийн авлага өглөгийг тооцохгүйгээр шууд зардлаар бүртгэсэн		1	1,763.0			1	1,763.0	1	1,763.0				
	ДҮН		1	1,763.0			1	1,763.0	1	1,763.0				

/Мянаан төгрөгөөр/

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянаан төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга		Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:											
			Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллага Д					
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2		3	4	5	6	7	8	9	10	11	12				
Эрдэнэбүрэн сумын ТТЗ	Төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийг программаас хасаж авлага буруулсан, 1 иргэний зээлийн үлдэгдлийн 511357 төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн зээлийн хүү 1602630 төгрөгийг нэмж бүртгээгүй, эдгээр нь Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэлгүй		1	9,021.5			1		1	9,021.5						
	Эвлэрлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг албадан гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулан ШШГА-тай гэрээ байгуулавгүй байна.		1	33,163.0					1	33,163.0						
	Хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг Шүүхэд хандаж шийдвэр гаргуулаагүй		1	18,726.5					1	18,726.5						
	ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлэх, төлөвлөх ажлын хэсэг томилж ажиллуулаагүй		1	0					1	0						
	Тайлант онд багийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй "Мөнгөлөг шагуурга", "Галдан		1	23,623.0					1	23,623.0						

